



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 0/80

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх ажилд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Объектын болон ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээ мэдээллийг хүргэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахад 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Иргэдэд объектын болон ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээ мэдээллийг хүргэх сурталчлан таниулах, санамж, тараах материалыг бэлтгэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 20-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Дүн
1	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	2	1.500.000	3.000.000
2	Объектын болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэргийлэх чиглэлээр иргэдэд тараах материал бэлтгэх	1300	1150	1.500.000
Нийт				4.500.000